



**Эцэг эх ба хүүхдийн
харилцаа**

Хүн болох багаасаа. Бага насны хүүхдийг “хүн” болоход хамгийн их нөлөөлөх хүчин зүйл нь гэр бүлийн төлөвшил. Эцэг эхийн амьдралын өдөр тутмын хандлага, дүр зураг, хүнийг үнэлэх үнэлэмжээр хүүхдийн зүрх сэтгэл төлөвшдөг. Тереза эх “Таны зүрх сэтгэлийн хайр хаанаас эхэлдэг вэ?” гэсэн хэн нэгний асуултанд “Би гэр бүл дотроо амьдрах ухаан, хүнийг хайрлахыг суралцсан” гэж хариулсан байдаг. Хэдийгээр гоё сайхан орд харшид амьдарч, тансаг хэрэглээтэй байсан ч эцэг, эх хоёрын хоорондын харилцаа муу гэр бүлээс хүүхдэд сайн үлгэр дууриалал ирнэ гэж хэлэхэд хэцүү.



Эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ харьцахдаа гаргадаг нийтлэг алдаанууд:

1. Эцэг эхчүүд өөрсдөө ч мэдэхгүй ажлаа хүүхдээсээ илүүд үздэг
2. Гэр бүл, хүүхэдтэйгээ хамт байх, Тэднийг санхүүгийн асуудалгүй байлгаж байгаагаа үр хүүхдээ хайрлаж байна гэж ойлгодог.



3. Хүүхэддээ цаг гаргахаа мэддэггүй,
тийм болохоор хүүхэдтэйгээ
төвөгшөөсөн байдлаар харьцаж энэ
байдал нь хүүхдээ тоохгүй болтлоо
даамжирдаг.

4. Хүүхдийнхээ хүссэн бүхнийг хүлээн
зөвшөөрч үгээр нь байчхаад сүүлдээ
дийлэхгүй тэсэхгүй болохоороо хүний
үгэнд ордоггүй гэж загнаж үглэн, гар
хүрч эхэлдэг.



“Тэр бүлийн доторх амгалан
тайван, эвтэй найртай, тав
тухтай байдал зэрэг нь хүүхдийн
СУУРЬ ХҮМҮҮЖИЛ-д маш чухал
нөлөө үзүүлдэг”



Асуулт 1:

Эцэг эх ба хүүхдийн харилцааг ямар байх ёстой гэж боддог вэ?

Асуулт 2:

Таны бодож байгаа шиг харилцаатай байж чаддаг уу? Үгүй бол яагаад тийм байгаа шалтгаан.



Өсвөр насны хүүхдүүдэд дарамт болон буруу хүмүүжил олгодог эцэг эхчүүдийн үйлдэл:

1.Шаардлагаа буруу тавьдаг.

2.Үглэж загнадаг.

3.Таалагдахгүй үг хэлдэг.

4.Доромжилж басамжилдаг.

5.Бусадтай харьцуулдаг.

6.Өөрийн үзэл бодлоо тулгадаг.



Эцэг эх хүүхэдтээгээ хэрхэн
яаж харицвал хүүхдийн
төлөвшилд сайнаар
нөлөөлж чадах вэ?





1. Сонс, Ярилц

2. Ойлго, Хүндэтгэ

3. Зөв харилц

4. Өөрийгөө өөрчил

5. Хандлагаа өөрчил

6. Хайрлаж энхрийл

7. Маш их үнс...



Эцэг эх болон хүүхдийн
харилцааг үр дүнтэй
болгох 4 арга:



ХАРИЛЦАН ХҮНДЛЭХ



Хүн төрөлхтний харилцааны ихэнх асуудал харилцан бие биеэ хүндэлж чадаагүйд оршдог. Эцэг эх нь хүүхдүүд маань биднийг хүндлэхгүй байна хэмээн бухимддаг. Тийм эцэг эх хүндлэл гэдгийг өөрийнх нь үйл хөдлөлөөс олж авсан гэдгийг, өөрөөр хэлбэл эцэг эх нь өөрсдөө бусад хүмүүсийг хүндлэх үед хүүхдүүд нь хажуугаас сурч байдаг гэдгийг мартсан байдаг. Бие биеэ хүндлэхийн тулд юуны өмнө эцэг эхчүүд үр хүүхдээ хүндлэж сурах хэрэгтэй. Тухайлбал, хамгийн энгийн арга бол зүй зохисгүй үг хэлэхгүй байх юм.



ЦАГИЙГ ХӨГЖИЛТЭЙ ӨНГӨРӨӨХ



Гэр бүлдээ зөв харилцаа тогтоох маш чухал. Цагийг хамтдаа өнгөрөөхөд хамгийн чухал нь хэмжээ биш харин чанар юм. Ганц цагийн нааштай, үр дүнтэй харилцаа нь хэдэн цагийн зөрчил тэмцэлээр дүүрэн харилцаанаас ч илүү үнэ цэнэтэй байдаг. Тиймээс 7 хоногт багаар бодоход 1 удаа гэр бүлээрээ хөгжилтэй цаг хугацааг өнгөрүүлж байвал гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа нь сэргэж бие биенээ хүндэлж хайралж эхлэнэ.



УРАМШУУЛАХ



Эцэг эх хүүхдэдээ итгэх ёстой.
Хүүхэд өөрийгөө “хүчтэй” гэж
итгэхэд туслахын тулд хүүхдээ
тасралтгүй урамшуулах
хэрэгтэй.

Нэгдсэн харилцаа нь хүүхэд
өөрөө өөрийнхөө талаар болон
эцэг эхийнхээ талаар хэрхэн
бодож байгаагаас шалтгаалдаг.

Хүүхдийг урамшуулах нь
хүүхдийн сайн талыг ойлгоход
тохиолдож болох алдааг
багасгахад маш чухал юм.



ХАЙРАА ИЛЭРХИЙЛЭХ

Ямар ч эцэг эх үр хүүхдэдээ хайртай байдаг. Гэвч эцэг эхчүүд хайртай гэж байнга хэлдэг ч үйл хөдөлгөөнөөрөө хэр үлгэрлэдэг вэ?



Хүүхдүүд амар тайван байдлыг мэдрэхийн тулд өөрөө хайрлаж, мөн өөрийг нь хайрлаж байгаа хүмүүс байх ёстой. “Ээж нь хүүдээ хайртай шүү” гэж үр хүүхдэдээ үгээр илэрхийлэх нь маш чухал.



**ХҮҮХЭД БҮХЭН ЭЦЭГ ЭХЭЭ САЙХАН
ХАРИЛЦААСАЙ, ОЙЛГООСОЙ, НАМАЙГ
ТОМ ХҮН БОЛЖ БУЙГ ХҮЛЭЭН
ЗӨВШӨӨРӨӨСЭЙ, ХҮНДЛЭЭСЭЙ ТЭЖ
ХҮСДЭГ.**



Дүгнэлт:

Хүүхдийн төлөвшилт нь 100% эцэг эхээс хамаардаг. Хэрвээ эцэг эх нар хүүхдээ зөв боловсон орчинд өсгөж мөн хайраа харамгүй зориулж чадвал хүүхдийн зан төлөв болон юмсыг харах өнцөг нь үргэлж эерэг байх болно.

